



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 05

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх, акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.2, 6.4.3, 6.4.6, 6,6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннаймдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 34,708,810,07 (гучин дөрвөн сая долоон зуун найман мянга найман зуун арван төгрөг долоон мөнгө) төгрөгийн балансын үнэтэй 9,916,802,87 (есөн сая есөн зуун арван зургаан мянга найман зуун хоёр төгрөг наян долоон мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй ЗДТГ-ын хуучин конторын барилгыг нэгдүгээр хавсралтын дагуу акталж, данснаас хасах, тус сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар барьж, ашиглалтад оруулсан нийт 185,313,096 (нэг зуун наян таван сая гурван зуун арван гурван мянга ерэн зургаа) төгрөгийн өртөгтэй Халуун усны барилга байгууламжийг хоёрдугаар хавсралтын дагуу тус тус Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Энхтуяа)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг Сум байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлого 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ




Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн  
05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын актлах хөрөнгийн мэдээлэл

№	Барилга байгууламжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтад орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа / жилээр /	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			хэмжих нэгж	биет хэмжээ					
1	ЗДТГ-ын барилга хуучин	Конторын барилга	м.кв	507.4	2002.07.01	7.00	34,708,810.07	24,792,007.20	9,916,802.87
Нийт дүн							34,708,810,07 /гучин дөрвөн сая долоон зуун найман мянга найман зуун арван долоон төгрөг мөнгө/ төгрөг	24,792,007,20 /хорин дөрвөн сая долоон зуун ерэн хоёр төгрөг хорин мөнгө/ төгрөг	9,916,802,87 /есөн сая есөн зуун арван зургаан мянга найман зуун хоёр төгрөг наян долоон мөнгө/ төгрөг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн  
05 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын  
газрын бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн мэдээлэл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ	Нийт дүн
1	Халуун ус- цэвэр усны шугам	м	80	69,080	5,526,400
2	Халуун ус- дулааны шугам	м	50	44,616	2,230,800
3	Халуун ус- бохирын шугам	м	50	111,760	5,588,000
4	Халуун усны барилга	ш	1	169,217,896	169,217,896
5	Агшин зуурын халаагч	ш	1	550,000	550,000
6	Агшин зуурын халаагч	ш	1	2,200,000	2,200,000
Нийт дүн				172,193,352 /нэг зуун далан хоёр сая нэг зуун ерэн гурван мянга гурван зуун тавин хоёр төгрөг/ төгрөг	185,313,096 /нэг зуун наян таван сая гурван зуун арван гурван мянга ерэн зургаан төгрөг/ төгрөг